



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР**

2022 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 03

Хөхөө

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай

Шинэ жилийн баяр ёслолын тэмдэглэлт өдрүүд эхэлж байгаа энэ үед хүйтний эрч чангарч байгаатай холбогдуулан хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн хэв журам алдагдах явдал, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ДААЛГАХ нь:

Нэг. Баг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч нарт даалгах нь:

1.1. Шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхдээ төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, 15.1.7 дэх хэсэгт заасан заалтыг хэрэгжүүлж ажиллах.

1.2. Шинэ жилийн баярын өдрүүдэд байгууллага, аж ахуйн нэгжүүд эргүүл, жижүүр томилон ажиллуулж, гэмт хэрэг, зөрчил, галын аюулаас, урьдчилан сэргийлж ажиллах

1.3. Шинэ жилийн баяр ёслолын өдрүүдэд архи, согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байх (12 дугаар сарын 31, 01 дүгээр сарын 01), Архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн хүнд согтууруулах ундааны зүйл өгөхгүй байх.

1.4. Мотоциклийн хөдөлгөөнийг түр хугацаанд хориглох тухай Аймаг, сумын Засаг даргын захирамжийг олон нийтэд сурталчилан хэрэгжүүлж ажиллах.

1.5. Байгууллага бүр 3 хүн албан ёсоор томилон Хөвсгөл аймгийн Цагдаагийн газар гэсэн нээлттэй групп-д лайк дарж нэгдэн, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг түгээх.

1.6. Албан байгууллага, аж ахуй нэгжүүд халаалт, дулааны аюулгүй байдлыг хангаж ажиллах.

Хоёр. Сумын цагдаагийн хэсэг (М.Буяннэмэх)-д даалгах нь:

2.1. Шинэ жилийн баяр ёслолын үед ажиллаж буй эргүүл жижүүрийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах.

2.2.Монгол улсын замын хөлгөөний дүрэм, Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын 520 тоот зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах.

Гурав.Ард иргэдэд даалгах нь:

3.1.Шинэ жилийн баярыг зөвхөн гэр бүлийн хүрээнд соёлтой тэмдэглэн өнгөрүүлэх.

3.2.Архи согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн хүнд согтууруулах ундааны зүйл өгөхгүй байх.

3.3.Цаг агаар хүйтэн байгаа энэ үед малчид, тээвэрчид тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, шатахууны нөөцийг хангаж ажиллах.

Сумын Засаг даргын 03 тоот албан даалгаварын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Баасанжав)-д даалгасугай.

ДАРГА



Л.ЭНХЖАРГАЛ